



156

**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 437

Хэрлэн сум

┌ Үнэлгээний ажлын хэсэг томилох тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2023 оны 301 тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", 442 тогтоолоор батлагдсан "Журам шинэчлэн батлах тухай" аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуйн газрын бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт болон гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж буй нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинд үнэлэлт дүгнэлт өгөх, үр дүнг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:-Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит

хариуцсан мэргэжилтэн

-Захиргаа, аж ахуйн албаны дарга

-Мал үржлийн албаны дарга

-Үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга, ерөнхий агрономч

-Хяналтын албаны дарга, хүнсний чанар

стандартын хяналтын улсын ахлах байцаагч

2.Хүнс, хөдөө аж ахуйн газрын бодлогын баримт бичгийг хууль болон тогтоол журмын дагуу үнэн зөв, тогтоосон хугацаанд нь тайлагнаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ХҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г. ГАНТӨМӨР

